



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Шинэ анагаах ухаан их сургууль

Хөтөлбөрийн нэр: Сувилахуй

Индекс: D091301

Шинжээчийн баг:

Ахлагч: Б.Оюунгоо

Гишүүд: Ю.Оюунзул

Н.Мөнгөнсор

Он сар өдөр: 2023.12.19

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

1	ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
2	БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл
3	ДХШҮА	Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний алба
4	МТМС	Мэдээллийн технологи, мэдээллийн систем
5	ОХА	Оюутны хөгжлийн алба
6	ОҮАУ	Орчин үеийн анагаах ухаан
7	ӨҮТ	Өөрийн үнэлгээний тайлан
8	УАУ	Уламжлалт анагаах ухаан
9	УКТЭ	Улсын клиникийн төв эмнэлэг
10	ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
11	СБЗА	Сургалтын бодлого зохицуулалтын алба
12	СЭЗБЗА	Санхүү эдийн засаг бодлого зохицуулалтын алба
13	СЭМТ	Сэтгэцийн эмгэг судлалын төв
14	ТТАХНЭ	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
15	ТШУ	Техникийн шинжлэх ухаан
16	ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
17	ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
18	ХШБ	Хий шар бадган
19	ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
20	Шинэ АУИС	Шинэ анагаах ухаан их сургууль
21	ACBSP	Accreditation Council for Business Scooland Programs
22	CLO	Course Learning outcomes (Хичээлийн сургалтын үр дүн)
23	NCM	Newly coded medicine
24	PDSA	Plan-Do-Study-Act
25	PLO	Program Learning outcomes (Хөтөлбөрийн сургалтын үр дүн)
26	s-NCM	УАУ ба ОҮАУ-ы нэгдмэл тогтолцооны NCM-д суурилсан шинэ мэдлэг

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Шинэ анагаах ухаан их сургууль / Newly coded medicine University/	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Сувилахуй / Nursing	
Индекс	D091301	
Шинжээчид	<ol style="list-style-type: none"> 1. АШУУИС-ийн Сувилахуйн сургуулийн захирал, АУ-ы доктор профессор Б.Оюунгоо 2. Хавдар судлалын үндэсний төвийн Сувилахуйн албаны дарга Ю.Оюунзул 3. Энэрэл дээд сургуулийн Сургалтын албаны дарга Н.Мөнгөнсор 	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Б.Мядагмаа – Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Ажлын албаны магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу
	2023.12.04	БМИҮЗ-өөс ӨҮТ-г шинжээчид хүлээн авсан.
	2023.12.04	Шинжээчдийн эхний уулзалтыг цахимаар зохион байгуулсан.
	2023.12.13-14	Шинжээч сургууль дээр ажилласан
	2023.12.19	Шинжээчид магадлан итгэмжлэлд орж буй сургуульд өөрсдийн тайланг илгээх.
		Мэргэжлийн зөвлөлийн комиссын шийдвэр
		Магадлан итгэмжлэлийн комиссын шийдвэр
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Шинэ АУИС нь 2017 оноос Сувилахуйн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд 3 удаагийн төгсөлт хийж, 33 төгсөгчийг хөдөлмөрийн зах зээлд нийлүүлжээ.

Хүн, амьтны биеийн протон хамааралт бүхэллэг тогтолцооны Систем загварын гол бүтцийн хэсгүүд - гол зангидмал - бүгдэд нөлөөлсөн хэсэг нь одоогоос 15 тэр бум жилийн өмнө орчлон үүсэхэд байсан анхдагч материаллаг зүйл нь болсон чөлөөт электрон, протон-кварк хэлбэрээр, нэг электрон, нэг протоноос тогтсон устөрөгч буюу анхны химийн элемент байдаг ба энэ нь бага Систем загварын параметрууд буюу Мембран-редокси потенциалын гурван төлөв шугам бий болоход хүргэсэн дараа нь Протоны урсгалын дамжлагат битүү хэлхээ буюу дунд систем загварын параметруудийг, дараа нь Их систем загвар буюу Протон хамааралт бүхэллэг тогтолцооны параметруудийг бий болгосон нь Сувилахуйн хөтөлбөрийн гол онолын хэсэг болсон.

Сувилахуйн хөтөлбөр бол хүмүүсийн алдагдсан эрүүл мэндийг Систем загварын гол параметрууд дээр олж тогтоон эрүүл төлөв рүү зүгшрүүлэх бүх талын мэдлэгийг эзэмшсэн мэргэжилтнийг бэлддэг бөгөөд Сувилахуйн хөтөлбөрийн сургалтын гол зорилго, шинжлэх ухааны нийтлэг үндэс нь - Их систем загвар буюу Хүн, амьтны биеийн протон хамааралт бүхэллэг тогтолцоо, Дунд систем загвар буюу Протоны урсгалын 9 дамжлагат битүү хэлхээ, Бага систем загвар буюу Мембран редокси потенциалын гурван төлөвт гэсэн өөр хоорондоо “протон” хамааралт үзэгдлээр холбогдсон гурван загвар дээр эм, эмчилгээний аргуудын үр дүн дутагдсан үед түүнийг сувилахуйгаар “нөхөх” төлөвлөлт хийх, нөхөгдсөн буюу каскад механизмын гол цэг зүгшрүүлгэнд орсон эсэхийг лабораторийн болон багажит шинжилгээгээр батлах нь “Сувилахуйн үйлчилгээний үр дүнт байдлын чанарын баталгаа” бөгөөд үүнийг “протоны хөдлөл зүй” ба 9 дамжлагат битүү хэлхээний Respiring tissue, Pulmonary circuit, битүү хэлхээний митохондри байрлалт 1-7-р үе шат, биоэволюцийн дивергенци- конверенци генетик үзэгдэлд суурилсан 10 гол тогтолцооны сүүлийн 800 сая жилийн биоэволюци- хүний биеийн 1, 2, 3, 4-р компартментийг тооцон үнэлгээ, оношилгоо, төлөвлөлт, хэрэгжүүлэлт, үр дүнг дүгнэн тооцох чадамжийг оюутан нэг бүрт эзэмшүүлэх нь хөтөлбөрийн гол зорилго нь болсон байна.

Хүн, амьтны биеийн амьд оршихын баталгаат үндэс болсон протоны урсгалын 9 дамжлагат битүү хэлхээний 8 болон 9- р үе шатанд - 1-7 үе шатанд үүсдэг протоны оролцоотойгоор R - T, T - R шилжилт нэг минутанд 16 удаа зүрхний 72 агшилттай уялдан явагдаж “ATP-charged battery- ADP+Pi -dead battery” хэвийн явагдах нөхцлийг бүрдүүлдэг үзэгдлийн гурвалсан холбоог сургалтын хөтөлбөрийн гол оновчлолд ашиглах цоо шинэ шийдлийг ашиглаж байгаагийн зэрэгцээ энэхүү шинэ тайлалыг Шинэ АУИС-ийн Сувилахуйн хөтөлбөрийн зорилго, хэтийн төлөвлөлт, шалгуур үзүүлэлтүүдийн чанарын баталгаажилт, оновчлолыг сайжруулах шинжлэх ухааны гол үндэслэл болгож, Сувилахуйн мэргэжилтэн төвөгтэй нөхцөлд олон хүчин зүйлийн дотроос оновчтой зөв шийдвэр гаргах арга зүйн үндэслэл болгоход анхааран ажиллаж байна.

Хүн, амьтны биеийн протон хамааралт бүхэллэг тогтолцооны Систем загвар дээр суурилан сургуулийн Хулж боржигон эмнэлэг нь Улирлын судас зэрэг УАУ-ы үнэ цэнэтэй мэдлэгийг Шинжлэх ухааны мэдлэг болгон хувиргаж, Сувилахуйн сургалтад ашиглаж эхлэх оролдлого хийж байгаа сургууль юм.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Шинэ АУИС-ийн Ректорын 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/29 тоот тушаалаар Сувилахуйн тэнхим байгуулагдаж, Ректорын 2021 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Б/39 тоот тушаалаар Сувилахуйн тэнхимийг Сувилахуйн сургууль, Ректорын 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн Б/63 тоот тушаалаар Сувилахуйн сургууль 3 тэнхимтэй болж өргөжин, Ректорын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн Б/40 тоот тушаалаар NCM-Сувилахуйн сургууль болсон тушаал
- NCM мэдлэг бүхий анагаах ухааны сургалтын хөтөлбөрийн гол цөм болсон амьд эсийн доторх мембран - редокси потенциалын гурван төлөв шугам хамааралт протон, электроны урсгалын 9 дамжлагат битүү хэлхээний тухай шинэ санаа - шинэ мэдлэгийг олон улсын шинжээчдээр үнэлүүлсэн байдал
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнг өөрийн сургалтын агуулга, үзэл баримтлалын онцлогтоо нийцүүлэн тодорхойлсон. Энэ нь байгууллагын эрхэм зорилго, байгууллагын соёл, хичээлийн хөтөлбөр болон хөгжлийн бодлогод нь шингэж уялдсан.
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, “Алсын хараа:2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д тусгасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой зорилго, зорилтын хэрэгцээт эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэж байгаа.
- Хөтөлбөрийн шинэчлэлийг хийхдээ Анагаах ухааны нийтээр хүлээн зөвшөөрөгдөн дагаж мөрддөг мэдлэг, чадварууд түүнийг улам нарийсган, өөрсдийн судалгааны үр дүнгээр баяжуулан нотолгоонд суурилсан боловсролыг хөгжүүлж байгаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хороогоор хөтөлбөрийн агуулгын шинэчлэлийг хэлэлцдэг, энэ зөвлөл дотор ректор, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд, СБЗА, ОХА, ДХШҮА оролцдог.
- Сургуулийг хөгжүүлэх 2016-2024 оны хөгжлийн мастер төлөвлөгөөтэй, богино, дунд, урт хугацааны төлөвлөлтөө дүгнэн, үр дүнг тооцдог. Одоогоор дунд хугацаа буюу 2019-2021 оны төлөвлөлтийн биелэлтэд дүн шинжилгээ хийсэн байна. Ингэснээр эрдмийн зэрэг цолтой багшийн хувь 50%, цалингийн өсөлт 2% хүрсэн, нийт багшийн тоо 94 болсон номын сангийн суудлын тоо 120 давсан байна.

Зөвлөмж:

- Гадаад дотоодын хөтөлбөртэй харьцуулахдаа зөв, үндэслэлтэй мэдээллийг ашиглах
- Хөтөлбөрт оролцогч талуудыг зөвхөн удирдагын багаас бүрдүүлэхгүй, багш, оюутан, ажил олгогчийн төлөөллийг оруулан тодорхойлж, тэдний саналыг хөтөлбөрт тусгадаг байх

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн зорилгоо тодорхойлсон
- Ректорын их семинар /Лекц №1, 2, 3, 4, 5, 6, 8, 9/, Шинэ АУИС-д хичээлийн нэг бүтэн жилд Анагаах ухаан, Эм зүй, Сувилахуйн хөтөлбөр 1-6-р курсэд заагддаг нийт 680 орчим кредит цагийн хичээлийг заахдаа хичээл нэг бүр дээр суурь мэдлэг болгон оруулах буюу “Б” мэдлэгийг “А” мэдлэг болгон чанаржуулахад баримтлах 26 - үндсэн чиглэлүүд /М.Амбага/-Ном
- Шинэ АУИС-ийн жил бүрийн зорилтонд тусгагдаж, “Сувилахуй-D091301” хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодит үндэс болж ирсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилго нь Их сургуулийнхаа эрхэм зорилготой нийцэж байгаа эсэхэд судалгаа хийж дүгнэсэн.
- ЭМЯ-наас баталсан Сувилахуй мэргэжлээр төгсөгчдөд тавигдах шаардлага, Монгол Улсын стандарт MNS5323-129: 2012 аар батлагдсан мэдлэг, чадвар хандлагыг хичээлийн хүрэх үр дүнтэйгээ холбон тодорхойлсон

Зөвлөмж:

- Оролцогч талыг бүрэн хамруулж тэдний хэрэгцээ шаардлагын дагуу хөтөлбөрийн зорилгоо томъёолдог байх
- Хөтөлбөрийн /PLO/ болон хичээлийн /CLO/ цогц чадамжийг Анагаах ухааны боловсрол судлал – шинжлэх ухааны үндэстэйгээр судалгаанд суурилан шинэчлэн боловсруулах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн хөтөлбөрүүд (Ректороор батлуулсан) бүгд баталгаажсан
- Хөтөлбөр богино хугацаанд сайжран хөгжиж байгаа нь тэнхимээс /2018/ сургууль /2021/ болтлоо хөгжсөн байдал нь харуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн шинэчлэлийг хийхдээ нуугдмал хөтөлбөрийг тодорхойлон гаргах, хичээлийг түргэн шуурхай ойлгож суралцах, шаардлагатай агуулгуудыг тусгах жишээ нь авилга, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх эрх зүй, гамшгаас хамгаалах хичээл, харилцааны ур чадвар, хос бичигтэн хөтөлбөрийг тусгасан ба сувилахуйн суурь Найтингелийн онолыг хичээлийн агуулгуудад оруулсан байна.
- Хичээл тус бүрийн зорилгыг хөтөлбөрийн зорилготойгоо уялдуулан гаргадаг ба багш оюутнуудад байх чадамж, зөөлөн ур чадварыг тодорхойлон оруулсан, хичээлийн тодорхойлолтыг гаргахдаа үндсэн стандарт тодорхойлолтоос гадна өөрсдийн эрхэм зорилго, хөтөлбөрийн хүрэх үр дүнтэйгээ уялдуулсан, хичээл бүрийн CLO тодорхойлсон

Анхаарах асуудал:

- CLO болон PLO уялдаа, матриц гаргах
- CLO болон хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөний уялдааг гаргах
- Хичээл болон заах арга зүйн уялдаа матриц гаргах
- Хичээл болон үнэлгээний аргын уялдаа матриц гаргах
- Сургалтын орчноо хуваарилан заах, хэдэн цаг нь УЧТ д, хэдэн цаг нь эмнэлэгт байх гэх мэтээр задлах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн багтаамж хэт их 188 кр байгааг журамд нийцүүлэн бууруулах
- Хичээлийн хөтөлбөрүүдийг (анхаарах асуудалд дурьдсны дагуу) шинэчлэн боловсруулах, хөтөлбөр дэх агуулга, төлөвлөгөөн дэх агуулгын хэмжээ зөрүүтэй байгааг засах

Шаардлага:

- Сургалтын хөтөлбөрийн агуулгын хэмжээ их, хичээлийн хөтөлбөрийн агуулга, төлөвлөгөөн дэх агуулгын хэмжээнээс зөрүүтэй байгааг арилгах

1-р шалгуурын шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Сувилахуйн бакалаврын хөтөлбөрийг БШУ-ны сайдын 2014 оны “Дээд боловсролын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага” А/174 тоот тушаалын дагуу боловсруулсан.
- Шинэ АУИС-ын захирлын 2014.11.06 өдрийн 119/1 захирлын тоот тушаалаар хөтөлбөрийн хороо 9 хүний орон тоотой байгуулагдаж, 2021.11.12 өдрийн А/54/01 тушаар 15 хүний орон тоотой дахин баталсан. 2017, 2022 онуудад хөтөлбөрийн шинэчлэл, сайжруулалтыг хийж хөтөлбөрийн дэд хороогоор 2 удаа хэлэлцүүлсэн.

- Шинэ АУИС-ын захирлын 2021 онд баталсан сувилахуйн сургалтын төлөвлөгөө нь 81 хичээлийн 188 багц цагийн багц цагийн багтаамжтай, бүтцийн ерөнхий суурь хичээл 26.06%, мэргэжлийн суурь 28.1%, мэргэшүүлэх хичээл 45.7% байгаа нь А/174 тоот тушаалын 2.2.1 заалтад тусгасан шаардлагыг хангасан.
- Хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүнг суралцагч, төгсөгч, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр үнэлдэг.
- Шинэ АУИС-ын “Сургалтын үйл ажиллагааны журмын 5.3, 5.7” үйлдвэрлэлийн дадлага хийх журмын дагуу 13 багц, 520 цагийн ерөнхий сувилахуй, төрөлжсөн сувилахуй-1, төрөлжсөн сувилахуй-2, төгсөлтийн өмнөх дадлагыг батлагдсан удирдамжаар 13 гэрээт (БГД ЭМТ, ЭХЭҮТ, ШЭНТ, ГССҮТ, ХУД ЭМТ, СХД ЭМТ, Бриллиант эмнэлэг, ХСҮТ, ХӨСҮТ, Геронтологийн ҮТ, УНТЭ, АӨСТ, Эмгэг судлалын ҮТ) эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулдаг. Дадлагын төгсгөлд тайлан бичиж, төлөвлөгдсөн зорилготой эмнэлзүйн шалгалтыг авч, үнэлгээний амжилт, чанараар анализ хийдэг.
- БШУС-ын 2021.10.06 өдрийн А/348 тоот тушаалын дагуу суралцагчийн ачаалал цагийг тооцож, хичээлийн хуваарийг удирдлага мэдээллийн системд оруулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл:

- Шинэ Анагаах Ухаан Их Сургуулийн эрдэмтдийн боловсруулсан Оюуны өмчийн патент бүхий NCM анагаах ухаан, NCM эм зүйд суурилсан хөтөлбөр, англи хэл дээр суурилсан Соёмбо хөтөлбөр, монгол хэл дээр суурилсан цөм хөтөлбөр гэсэн сургалтын ГУРВАЛСАН ХӨТӨЛБӨР-ийн агуулгаар Дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн Шинжлэх ухааны түгээмэл зүй тогтолд тулгуурлан хичээлийн хөтөлбөрийн онолын агуулгын 10%-д тусгаж сувилахуйн бакалаврын хөтөлбөрөөр суралцагчдад мэдлэг олгодог.
- Төгсөгчдийн гадаадад ажиллах боломжийг нэмэгдүүлэх үүднээс гадаад хэл тухайлбал Англи хэл-1,2 хичээлийг 4 багц цаг, Япон хэл-1,2, 3,4 хичээлийг 8 кр зааж сургадаг.

Анхаарах асуудал:

- Сургалтын үйл ажиллагаа болон хөтөлбөр боловсруулахад ажил олгогчдын саналын авч, хамтран боловсруулах, хэрэгжүүлдэг байхад анхаарах.

Зөвлөмж:

- Сувилахуйн хөтөлбөрийн агуулгыг шинэчлэн сайжруулахад ажил олгогчдын саналыг авч оролцоог хангах

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын арга зүйг БШУ-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаал, Шинэ АУИС-ийн 2017 оны А/13 тоот “Сургалтын үйл ажиллагааны журам”-аар хэрэгжүүлдэг.
- Хүн, амьтны биеийн протон хамааралт бүхэллэг тогтолцооны систем загварт суурилсан сургалтын шинэчлэн хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг.

- Сувилахуйн сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөөнд заавал судлахаар тусгагдсан 88 хичээлийн сургалтанд ашиглаж буй сургалтын аргуудыг нэгтгэн дүгнэхэд интерактив 83.7% (ЕС-12, МС-19, МШ-36 хичээл), ойлголтын буюу тулгуур асуултын аргад суурилсан 77.5% (ЕС-6, МС-19, МШ-37 хичээл), ажлын байрны сургалт буюу эмнэл зүйд бааз орчинд суурилсан 42.5% (МС-4, МШ-30 хичээл), эмчлүүлэгчийн дэргэдэх гардан ур чадвар эзэмших сургалт буюу орны дэргэдэх сургалт 41.25% (МС-2, МШ-31 хичээл) сургалтын арга зүйг түлхүү ашигладаг.
- Төгсөлтийн шалгалтыг OSCE (Төлөвлөгдсөн зорилготой эмнэл зүйн шалгалт), Эмнэл зүйн сургалтанд SCORPIO аргыг хэрэглэдэг./ тухайн аргыг 5 мэргэжлийн багш нар хамтран зохион байгуулдаг. Хичээлийн судалгаа хэлбэрээр жирэмслэлт, төрөлт, төрсний дараа тусламжийг дадлагын хичээл дээр хийж бататгаж ирсэн.
- БШУЯ-ны сайдын 2020 оны 11 сарын 11 А146 тоот тушаал, Шинэ АУИС-ийн захирлын 2021.09.01 өдрийн А/28/04 “Цахим болон танхимын сургалт явуулах” журмыг тус тус үндэслэн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг. 2022 оны хичээлийн жилээс сургалтын /X cloud/ үүлэн программын сургалтанд ашигласан. Сургалтын программд E хичээлийн тоо 803, Сорилын тоо 2496, Оюутны тоо 103, хандалтын тоо 3210 байгаа нь оюутнууд үр дүнтэй цахимаар суралцах боломж олгодог. 2020-2021 оны хичээлийн жилд сургалтыг цахим хэлбэрээр Zoom, google classroom, google meet системийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Шинэ АУИС-ын эрдэмтдийн боловсруулсан оюуны өмчийн эрх бүхий NCM анагаах ухаан Хүн, амьтны биеийн протон хамааралт бүхэллэг тогтолцооны систем загварт суурилсан сувилахуй, англи хэл дээр суурилсан Соёмбо хөтөлбөр, Монгол хэл дээр суурилсан цөм хөтөлбөр гэсэн сургалтын гурвалсан хөтөлбөрийн агуулгаар Дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн ШУ-ны түгээмэл зүй тогтолд тулгуурлан хичээлийг өөрийн онцлогт тохируулан “А” мэдлэг буюу гардан хийсэн ажиглалтын үр дүнгээ зөв үндэслэлтэйгээр эзэмшүүлэх арга зүй (7), “Б” буюу гадаад, дотоодын боловсрол олгох сургалтын сурган заах арга зүй (10)-г гэсэн хоёр зэрэгцсэн сурган арга зүйг В буюу оюун бодолдоо “өөрийн” гэсэн мэдлэгийн орон зай руу хувиргадаг, өөрийн мэдлэг - өөрийн байр суурийг төлөвшүүлсэн, тэр мэдлэг, хандлагын эзэмшүүлэх В гэсэн сурган арга зүй (3)-г ашиглах гэсэн зарчмаар сувилахуйн сургалтын хөтөлбөрт 21 төрлийн сурган заах арга зүйг ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Сувилахуйн сургалтын удирдлагын баг, тэнхимийн багш нар хичээлийн суралцахуйн үр дүнг /CLO/ сургалтын арга, хүргэх хэлбэртэй хамааруулан тодорхойлоход анхаарах.

Зөвлөмж:

- Багш нарын сургалтын үйл ажиллагаанд хэрэглэж байгаа аргуудын үр дүнг тооцож, хөтөлбөрийн хүрэх үр дүнд хүрэхүйц сургалтын аргуудаас хөтөлбөрт хичээлийн суралцахуйн үр дүнг /CLO/-г сургалтын арга, хүргэх хэлбэртэй хамааруулан тусгаж боловсруулах.
- Сургалтын үйл ажиллагаанд сургалтын дэвшилтэд технологи ашиглах, сувилахуйн түгээмэл үйлдлийг стандартын дагуу E контент боловсруулах.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Шинэ АУИС-ийн 2017 оны А/13 тоот тушаал “Оюутны мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх журам”-аар сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн хөтөлбөрийн дагуу оюутны мэдлэг олж авах, ур чадвар эзэмших, хандлага төлөвших үйл явцыг хянаж, дүгнэх үйл ажиллагааг зохицуулдаг. Үүнд
- Сувилахуйн хөтөлбөрийн сургалтанд мэдлэгийг сорилоор 81.2%, асуулт (аман) хэлбэр 62.5% үнэлдэг. Харин гардан ур чадварыг ажиглалтын үнэлгээ /DOPS/ 48.7%, Эмнэл зүйн дасгал үнэлгээ / Mini-CEX/ 46.2%, Кейс (бичгэн хэлбэрээр) 38.7% хэлбэрүүдээр хичээлийн үр дүнг үнэлэдэг.
- Их Сургуулийн оюутан нь дадлагын хичээлийн үед өөрсдөө гардан хийсэн ажиглалтын үр дүнгээ зөв үндэслэлтэйгээр ойлгосон “А” мэдлэг болон “Б” буюу гадаад, дотоодын багш, эрдэмтдийн ном сурах бичгээс олж авсан хоёр зэрэгцсэн мэдлэгээ В буюу оюун бодолдоо “өөрийн” гэсэн мэдлэгийн орон зай руу хувиргадаг, өөрийн мэдлэг - өөрийн байр суурийг төлөвшүүлсэн, тэр мэдлэг, хандлагаараа шалгалт өгч, багшаар В хэсгээрээ “өөрийнхөө” чадамжийг үнэлүүлдэг бие хүн - оюутан байх ёстой.
- Оюутан суралцагчдын үнэлгээний нэгдсэн систем нь “сурах, сургах” үйл ажиллагааг бодитой үнэлэх, сургалтын үйл явцыг удирдах, зохицуулах, нэгдсэн бодлого хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Жишээ нь
- Хүүхдийн сувилахуй хичээлийн үнэлгээ

А чадамж

- Аман шалгалт
- Олон хувилбарт сорил /MCQ/
- Уялдуулан сонгох сорил /EMI/
- Эмнэл зүйн дасгал үнэлгээ / Mini-CEX/
- Гардан гүйцэтгэлийн ажиглалтын үнэлгээ /DOPS/

Б чадамж

- Портфолио үнэлгээ

В чадамж

- Урт болон богино хэлбэрийн эмнэл зүйн тохиолдол / CASE /

Онолын шалгалтыг олон хувилбарт сорил, Е сорил ашиглан үнэлдэг. Ур чадварыг Төлөвлөгдсөн зорилготой эмнэлзүйн шалгалт (ТЗЭШ), төлөвлөгдсөн зорилготой гардан шалгалт (ТЗГШ), өртөөчилсэн (сувилахуйн ур чадвар, дотор өвчний сувилахуй, хүүхдийн сувилахуй, эхийн сувилахуй, мэс заслын сувилахуй, хоолоор сувилахуй), урт болон богино хэлбэрийн тодорхой хугацаанд эмнэлзүйн мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сувилахуйн багш нар сувилахуйн төгсөлтийн шалгалтын өртөө тус бүрийн тохиолдол, үнэлгээний хуудас бүхий оюутны гарын авлагыг боловсруулах

2-р шалгуурын шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын үйл ажиллагаа явуулах орчны болон технологийн нөхцөл нь “Дээд боловсролын байгууллага байгуулахад тавигдах нийтлэг шаардлага” норм нормативыг хангасан байна. Сургуулийн нийт талбай 3505,8м², эзэмшил газрын байршлын кадастрын зураг, сургуулийн план зургууд давхар бүрээр хийгдсэн. Сургалт болон дадлага явуулах анги танхим, багш хэрэгсэл, багшийн ажиллах орчин хөтөлбөрийн хэсэгт нотлох баримтаар сувилахуйн бакалаврын ангийн оюутнууд дадлага хийх өрөө 2, семинар хийх 2 өрөөтэй ба сургалт явуулах анги танхим нийт 120 м2 талбай бүхий байна. Одоо сувилахуйн ангид сурч байгаа 95 оюутан байгаа бөгөөд нэг оюутанд ноогдох талбай хичээлийн байранд 3,43 м2 байна. Сувилахуйн тэнхим нийт 9 багштай, багш нарын боловсролын зэрэг доктор 1, магистр 2, мэргэжлийн зэрэг тэргүүлэх зэрэгтэй 3, ахлах зэрэгтэй 4 байна. Үүнээс Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн дадлагын багш 5, сургуульд сувилахуйн багш 4 байна. Сувилахуйн багш нар нийт 3 өрөөтэй, нэг багшид ноогдох талбайн норм 4м2 байх нормд хүрэлцээтэй байна. Багшийн хөгжлийн төвийг сургуулийн 1-р байрны 603 тоот өрөөнд зохион байгуулж үйл ажиллагаа явуулдаг.
- Сургуулийн багш оюутанд зориулсан хоолны газартай, түрээсийн гэрээтэй ажилладаг ба хөнгөлөлттэй үнээр үйлчилдэг хоол хүнс зарж байна. Багш нарт зориулсан өдрийн хоолыг цайны газарт үнийн хөнгөлөлт үзүүлдэг. (талон 6000-6500 төг) Баруун сэлбэ улсын нэгдсэн оюутны байранд тус сургууль нийт 48 оюутны ор бүхий өрөөтэй ба одоо 32 оюутан амьдарч байна. Оюутанд зориулсан ус шүүгчийн тоо 3 ш байна, оюутан болон багш ажилчдад оюутны зоогийн газар 4500-6500 төгрөгөөр хөнгөлөлттэй хоолны үнээр үйлчилдэг. Оюутны зоогийн газрыг түрээслэгчтэй түрээсийн гэрээний дагуу хамтран ажилладаг. Оюутанд зориулсан хувцасны локерын тоо хичээлийн 3 байранд нийт-150ш, хамтран ажилладаг гэрээт эмнэлгүүд дээр нийт 150ш, сандлын тоо 750 оюутнууд сууж хичээллэхэд хүрэлцээтэй суудалтай байна. Сургуульд ариун цэврийн өрөөний суултуурын тоо нийт 21 ш, угаалтуур 25 ш, хувцас солих өрөө 2, хувцасны өлгүүрийн тоо 220-250 ш, мөн оюутанд зориулсан хувцасны шүүгээг хүрэлцээтэй байршуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Анхаарах асуудал:

- Сувилахуйн багш нарын мэрэгшүүлэх зэрэг дутагдалтай байна

Шаардлага:

- Сувилахуйн гардан ажилбарын сургалтын өрөөг эмнэлгийн орчинд дүйцүүлэх, багаж хэрэгслэл, аппарат тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Багш нар сургалтын батлагдсан ур чадварын хичээлийн хөтөлбөртэй, лайв вебинар хичээл ороход ашигладаг программтай, багш нар classroom, face group, google meet, cloud систем ашиглаж байна. Мөн номын сангийн ажилд олон улсын номын сангийн RDA стандартыг ашигладаг Koha программ хангамж, мөн Lib4U программ авч ашиглан нэвтрүүлж уншигч оюутан, магистрант, багш нарын system бүртгэлд оруулан үйлчилгээг түргэн шуурхай орчин үеийн тохилог мэдээллийн, нээлттэй номын санг байгуулсан байна. Уг программд 2022 оны эцэст 1850 уншигч, 30297 гаруй ном бүртгэлтэй бөгөөд нээлттэй электрон номын сан ESAN-д эрдэм шинжилгээ судалгааны ажлын материалууд, 250 гаруй магистрын ажлын диссертацыг 2 байгууллагын хамтарсан гэрээгээр байршуулсан байна.
- Сувилахуйн сургалтанд хэрэглэж байгаа багаж материал тоног төхөөрөмжийн нийт 41 жагсаалт бүхий байна, жагсаалтыг нотлох баримтаар хавсаргав. Сургалтын хэрэглэгдэхүүнд ширээ, сандал, шүүгээ, компьютер, дэлгэц, самбар, сургалтын муляж 8ш, үүнээс бүтэн биеийн муляж 2ш, хэсэгчилсэн муляж 6, эмнэлгийн ор 2ш, үүнээс стандартын ор 1ш, сувилагч тэргэнцэр 2ш зэрэг байна. Сувилахуйн мэргэжлийн, мэргэшүүлэх хичээлүүд 2,3 дугаар шатлалын гэрээт 13 эмнэлэгтэй гэрээтэй ажиллаж мэргэжлийн болон мэргэшүүлэх 24 хичээлийг оруулж оюутанд мэдлэг, чадварыг эзэмшүүлж байна. Оюутны түшиц эмнэлэг Хулж боржигон нь 25 ортой бөгөөд энд оюутнууд сувилахуйн гардан үйлдлийн дадлагыг хийдэг байна. Мөн эмнэлгийн яаралтай тусламжийн өрөөнд сургалтыг зохион явуулдаг ба тодорхой хэмжээний аппарат тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Сувилагч мэргэжилтэн бэлтгэх сургалтын удирдамж 3, багш нартай хобоотой журам 31, оюутантай холбоотой сургалтын үйл ажиллагааны журам 12 байна. Үүнд: Багш нарын удирдамж 3, Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний удирдамж, Насанд хүрэгчдийн артерын гитертензийн эмнэлзүйн заавар дахь сувилахуйн тусламж үйлчилгээний удирдамж, Томуу томуу төст өвчний үед үзүүлэх сувилахуйн тусламжийн үйлчилгээний удирдамж, Оюутны ёс зүйн дүрэм, оюутан сургах гэрээ, Оюутны мэдлэг чадвар, хандлагыг үнэлэх журам, оюутны шилжилт хөдөлгөөний тухай журам, оюутны бие даалтын журам, “Оюутны Зөвлөл”-ийн үндсэн чиглэл, “Шинэ Анагаах Ухаан” Их сургуулийн төгсөлтийн шалгалтын журам, үйлдэх журам, Оюутны дотуур байрны дүрэм, оюутны үйлдвэрлэлийн дадлагын ерөнхий журам, Оюутны хөдөлмөр эрхлэлтийн дэмжих төвийн журам, Оюутны хувцаслалтын талаар баримтлах журам зэрэг байна. Мөн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам, болон бусад үйл ажиллагаатай холбоотой дүрмүүдийг баримтлан ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Номын сангийн үйл ажиллагаа, номын баяжилт маш сайтай, ном ариутгагч шинээр авсан байна

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Номын сангийн ажиллах MNS 5742:2019 стандартыг ханган ажиллаж байна. Номын жагсаалтуудыг унших болон цахим хэлбэрээр ангилалт хийсэн ба багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангагдсан байна. Номын сан нь уламжлалт анагаах ухаан, анагаах ухааны эмч, эм зүйч, сувилахуйн мэргэжлээр суралцаж буй оюутнуудад зориулагдсан ном хэвлэлээр фондоо баяжуулсан байна.
- Сургуулийн номын сангийн орчин 138 м² талбайтай, 85 хүний суудалтай чөлөөт сонголттой, нээлттэй уншлагын танхим, 36 м² талбай бүхий гэрээр ном олгох фондтойгоор үйлчилгээ үзүүлж байна. Номын сангийн ажилд олон улсын MARC 21-г дэмждэг орчин үеийн Коха программ хангамжийг ашиглан фондын бүх ном хэвлэлийг электрон каталогид оруулан үйлчилгээ үзүүлж байна. Номын фондыг <http://112.72.15.115> хаягаар орж шүүлт хийж, электрон каталогтой танилцаж болох ба үнэ төлбөргүй Wi-Fi орчинг бүрдүүлж өгсөн байна. Мөн CD-ROM, e-book, видео аудио зэрэг үйлчилгээг шинээр буй болгох чиглэлээр ажлуудыг хийж электрон хэлбэрээр ашиглах номын фонд 185 байна. Номын сангийн фондыг жил бүр 15 гаруй сая орчим төгрөгний баяжилт хийдэг ба 2022 оны эцсийн байдлаар байдлаар монгол, англи, орос, төвд болон бусад хэл дээр бичигдсэн 32200 гаруй ном, хэвлэл, цахим ном, эрдэм шинжилгээний бүтээлүүдтэй болоод байна. Нэг оюутанд 7-10 сурах бичиг, 16 орчим гарын авлага, мэргэжлийн ном, номын хангамж 1 уншигчид 30 орчим ноогдож байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд номын фондын нийт номын тоо 2015 онд 25562 байсан бол 2016 онд 1,02 дахин, 2017 онд 1,04 дахин 2018 онд 1,05 дахин, 2019 онд 1,03 дахин, 2020-2022 онд 1,02 дахин нэмэгдсэн байна. Үүнээс сурах бичиг, гарын авлага 1,05-1,08 дахин, бусад ном сурах бичгийн тоо 1,1-1,23 дахин нэмэгдсэн байна. Ном ариутгагч шинээр авсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ном ариутгагч авсан

Анхаарах асуудал:

- Номын санд дуу багасгагч нэмж хэрэглэх (шал, хана), ширээнд тусгаарлагч кабин нэмж хийх

3-р шалгуурын шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн удирдлага зохион байгуулалтын бүтэц цикл
- Сургуулийн бүтэц
- Сувилахуйн хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын мэдээлэл, тушаал
- Шинэ АУИС-ийг 2016-2024 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Удирдлагын зохион байгуулалтын бүтэц циклийг мөн цагираг хэлбэрээр тодорхойлсон бөгөөд ректор, проректорын зүгээс хөтөлбөрийн шинжлэх ухаанч байдлыг хангах, шийдвэрээ гүйцэтгэгч алба нэгжүүдэд албажуулан хүргэх, алба нэгжүүд бүрэлдэхүүн сургуулиудад дамжуулан хэрэгжүүлэхэд чиглэх, бүрэлдэхүүн сургуулийн захирал нь тэнхимийн эрхлэгчдээр дамжин үйл ажиллагааг хяналттайгаар, эргэх холбоотойгоор зохион байгуулдаг
- Ажлын даалгаварт төвлөрөхөөс илүү ажлын үр дүнд төвлөрөн ажиллах тул ажлын цагийг уян хатан горимд оруулсан
- Удирдлагаас даалгах, удирдлагаас суралцах гэхээс илүү бие биенээсээ суралцах хандлага руу шилжсэн
- Оролцогч болон сонирхогч талуудын санал, гомдол, хүсэлтийг хүлээн авах урсгалтай, жил бүр төрлөөр нь нэгтгэн танилцуулдаг.
- Багшийн гарын авлагад сургуулийн бүх дүрэм журмыг багтаан гаргасан ба бүх багш нарт тараагдсан байдаг.

Анхаарах асуудал:

- Хэдийгээр бүтэн циклээр удирдлага зохион байгуулалтыг гаргадаг ч оюутнаас удирдлага хүртлээ, багшаас удирдлага хүртлээ хол, хөтөлбөрийн бодлогын шийдвэрт багш нарын санал тусгагдаггүй
- Хөтөлбөрийн хороо болон тэдний хийж байгаа ажлыг багш нар бараг мэдэхгүй байна

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнд багш, оюутан, ажил олгогчийн төлөөллийг оруулах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хамтын ажиллагаа, Гэрээт эмнэлгүүд, нийгэмд үзүүлэх үйлчилгээ
- Хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжсэн ажлууд
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс нийгэмд үзүүлж буй үйлчилгээний талаар
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа тогтмолжсон байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Судалгааны ажлын чиглэлээр гадаад болон дотоодын олон хамтрагч, харилцагчтай
- Хамтарсан судалгаа сайн
- Хамтран ажилладаг 13 эмнэлэгтэй хүчин төгөлдөр гэрээтэй, хөдөө орон нутагт Хэнтий аймагт дадлага хийдэг
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг эхлүүлсэн

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийг хөтөлбөрийн шинэчлэлд оролцуулах, тэдний дуу хоолойг сонсох, хөтөлбөрийг үнэлэхэд анхаарах

Зөвлөмж:**4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Санхүүжилт
- Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж үр нөлөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн судалгааны чиглэлээр хөгжих нөхцлийг бүрдүүлж шинэ лабораторийг 250 сая төгрөгөөр байгуулсан
- Багш нарт нийгмийн асуудлыг шийдэх хүрээнд хүүгүй урт хугацааны зээл болон буцалтгүй тусламжийг олгодог

Анхаарах асуудал:

- Нийт гүйцэтгэлийн 1 орчим хувь нь хичээл практикийн зардал, 0,1 орчим хувь нь оюутанд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулагдаж байгаа нь бага байгааг анхаарах
- Багшийн хөгжлийн хөтөлбөрт зарцуулах зарцуулалтын хувь бага 0,01 хувийг эзэлж байна

Зөвлөмж:**4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сургууль болон хөтөлбөрөө танилцуулсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- ТВ ээр 18 сонин сэтгүүлд 4 олон нийтийн сүлжээ сошиалаар 5 сувгаар мэдээллийг түгээсэн

- Маркетингийн үйл ажиллагааг тогтмол хийдэг

Анхаарах асуудал:

- Тогтвортой тогтмол үйл ажиллагааг явуулдаггүй, элсэлтийн үеэр илүүтэй хийгддэг
- Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн хүртээмж, үр нөлөөг хэрхэн тодорхойлдог нь тодорхой бус.
- Хөдөлмөрийн зах зээлийн тандалт судалгааг тогтмол хийж, төгсөгчдийнхөө ажиллаж буй байгууллага, ажил олгогчдоос тэдний цогц чадамжийн талаарх судалгаа авч өөрсдийн маркетингад ашигладаг байх

Зөвлөмж:

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал ба Удирдлагын багийн бодлого

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаад ном хэвлэлийн 2 компанитай судалгааны үр дүнг хуваалцан, хэвлэлийн эрхийг өгч, дэлхийн цахим худалдааны сүлжээнд байршуулсан
- Олон нийтийн хэрэгслээр ярилцлага мэдээллийг өгч нээлттэй байдлыг бүрдүүлдэг

Зөвлөмж:

- Вебсайтын мэдээ хэт хуучирсан, ашиглалт болон хандалт багатай байгааг анхаарах, шинэчлэх, хөтөлбөрийн талаарх мэдээллийг байршуулах

4-р шалгуурын шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Шинэ АУИС нь элсэлтийн үйл ажиллагааг Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 7.3, 12.1.6 дахь БШУЯ А/79 тоот тушаалаар батлагдсан оюутан элсүүлэх журам, БШУЯ-ны 2023.03.14-ний өдрийн А/97 тоот “Босго оноо тогтоох тухай” тушаалыг үндэслэн “Оюутан элсүүлэх” журмыг 2023 оны 05 сарын 11 А/29 өдөр шинэчлэн баталсан бөгөөд оюутан элсүүлэх хяналтын тоог сургуулийн удирдах зөвлөл батлан бүрэн дунд боловсрол эзэмшсэн, ЭЕШ-1 хими-400, математик-400 хичээлүүдээр амжилттай үнэлэгдсэн, элсэхийг хүсэгчдийг хичээлийн онооны дарааллаар, ЭЕШ-2 ур чадварын шалгалтын оноогоор элсүүлэх болсноор тухайн мэргэжлийг сонгон суралцах суралцагчдын тоо

нэмэгдэх хандлагатай байна. Элсэлтийн бүртгэлийн үйл ажиллагаа 2020 оноос NCM.elseit.mn сургуулийн элсэлтийн программаар цахим хэлбэрт бүрэн шилжсэн.

- Шинэ АУИС-ийн сувилахуйн бакалаврын хөтөлбөрт 2021-2022 оны хичээлийн жилд 32, 2022-2023 оны хичээлийн жилд 24, 2023-2024 оны хичээлийн жилд 30 суралцагч элссэн нь сүүлийн 3 жилийн байдлаар элсэгчийн тоо ойролцоо байна.
- Шинээр элсэн суралцагчдад зориулан хичээлийн эхний өдөр Ректор хүндэтгэлийн лекцийг уншиж, “Удиртгал хичээл”-ийг тусгайлан гаргасан хуваарийн дагуу сургуулийн танилцуулга, оюутны дүрэм, журам, хувь хүний хөгжил, суралцах арга барил эзэмшүүлэх агуулгын хүрээнд танхим болон цахим байдлаар сургалтыг оюутны хөгжлийн албанаас зохион байгуулдаг.
- 2021-2022 оны хичээлийн жилээс оюутны гарын авлагыг шинэчлэн боловсруулан цахим болон хэвлэмэл байдлаар оюутан бүрт хүргэсэн. Сургуулийн цахим сайтуудаар мэдээллийг тогтмол өгч ажилласан байна.
- Оюутанд зориулсан гарын авлагыг сургуулийн номын санд байршуулан сургалтын үйл ажиллагаа, оюутанд чиглэсэн үйлчилгээ, оюутны мөрдөх дүрэм, журам зэрэг холбогдох мэдээллээр ханган ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Профессор М.Амбагын “Хүн, амьтны биеийн протон хамааралт бүхэллэг тогтолцооны систем загвар”-ын шинэ мэдлэгээр системтэйгээр суралцах. Сувилахуйн ангийн суралцагч, төгсөгчид Япон улсад мэргэжлээрээ ажиллах боломжийг хангаж өгсөн.

Анхаарах асуудал:

- Сувилахуйн хөтөлбөрт элсэгчийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах.

Зөвлөмж:

- Сувилагч мэргэжилтний хүний нөөц дутмаг ЭМБ-тай хамтран ажиллах, сургалтын үйл ажиллагааг ажлын байран дээр зохион байгуулах боломж нөхцөлийг судлах.
- Элсэлтийн журамд сувилахуйн элсэгчдийн тоог нэмэгдүүлэхэд сувилахуйн тэнхимийн багш нарын багийн оролцоог сайжруулах.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Шинэ АУИС нь суралцагчид зөвлөн туслах үйлчилгээг сургалт, мэдээ мэдээлэл, ахуйн, соёл хүмүүжлийн 11 чиглэлээр үзүүлдэг.
- Оюутны сурлага хүмүүжил, олон нийтийн ажлыг зохион байгуулах, санаачлах, оюутны эрх ашгийг хамгаалах, оюутнуудын санал хүсэлтийг сургуулийн захиргаанд хүргэх, холбох, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд сургуулийн оюутны хөгжлийн алба, оюутны зөвлөл, сайн дурын 5 клуб (Энэрэнгүй үйлстэн улаан загалмай клуб, оюутны соёл урлагийн клуб, NCM бэрс шатрын клуб, student medical ensemble, innovate) идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг. Оюутны зөвлөлийн хүрээнд хийгдэж буй төсөв, санхүүгийн асуудлыг сургууль дэмждэг бөгөөд тайланд тусгагдсан байна. Үйл ажиллагааны тайланг тогтмол гарган хавтасжуулсан.

- Ректор пүрэв гараг бүр цахимаар ангийн дарга, оюутны төлөөлөлтэй хэлэлцүүлэг уулзалт хийж, санал хүсэлт, асуулт хариултыг нээлттэй байдлаар зөвлөн туслах үйлчилгээг үзүүлдэг. 2022 оны хичээлийн жилд ус шүүгчтэй болох хүсэлтийн дагуу 2ш ус шүүгчийг байршуулсан. Мөн оюутны амрах өрөөтэй болох хүсэлтийн дагуу сургуулийн 2 давхарыг тохижуулсан. Сургуулийн гадна орчины эвдрэлтэй явган хүн зорчих замыг засварласан.
- Сэтгэл судлал багш бие хүний сэтгэцийн хэв шинж, сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг хүн бүрт, зүрхээ дайлая зэрэг сэдвүүдээр бүлгийн сэтгэл засал эмчилгээ, сургалтыг нийт 40 оюутанд зохион байгуулсан, сэтгэцийн тулгамдсан асуудалтай болон сэтгэлзүйн зөвлөгөө мэдээлэл авах шаардлагатай 5 оюутанд ганцаарчилсан сэтгэлзүйн зөвлөгөө өгсөн.
- Хичээлийн жил бүр Сонгино хайрхан дүүргийн цагдаагийн 2 хэлтэстэй хамтран оюутныг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулдаг.
- Сургуулийн удирдлагын зүгээс “Оюутанд дарамтгүй сургууль” гэсэн уриаг санаачлан ажиллаж, оюутны хөгжлийн албанаас ажилтан, албан хаагчдын харилцаа, мөн сургалтын чанар, багшийн ур чадвар, багшийн харилцаа, хандлагаар суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авдаг.
- Б.Саранцэцэг багш 3-аас дээш дамжааны оюутнуудад эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хэм хэмжээ, харилцаа хандлагын талаарх сэдвүүдээр лекц уншдаг.
- Шинэ АУИС-ийн NCM эрдэм шинжилгээний хүрээлэн, эрдэм шинжилгээний ажилтан, туршилтын амьтан бүхий виваритай нь оюутнуудыг судалгааны ажил хийх боломжоор хангаж, нотолгоо баримтад суурилсан байдлаар сургалтыг зохион байгуулдаг. Тухайн хүрээлэн NCM анагаах ухааны тэнхим хамтран тогтмол оюутны эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгуулдаг.
- АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн судлаач оюутан-2021 оюутны эрдэм шинжилгээний хуралд сувилахуйн бакалаврын 4 дамжааны 2 оюутан “Бөөрний өөрчлөлттэй жирэмсэн эхэд сувилахуйн тусламжийг үзүүлэх нь” сэдвээр амжилттай оролцсон.
- АШУҮИС-ийн эрдмийн чуулган-64 сувилахуйн салбар хуралдаанд сувилахуйн 4-р дамжааны 3 оюутан хамтран “СХД-ийн ЭМТ-ийн 3 дугаар амбулаторийн эмч, сувилагч нар ковид-19 вирусын халдварт өртсөн эрсдлийн байдалд хийсэн судалгаа” сэдвээр амжилттай оролцсон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус сургуулийн ректор санаачлан ажлын 5 өдөр өглөө бүр 07 цаг 30 минутанд оюутны хөгжлийн албатай хамтран оюутнуудын майл цахим хаягаар англи хэл дээрх оюутнуудад зориулсан 3 хувилбарт сургалтын шинэ технологийн (Соёмбо хөтөлбөр) 100-256 хичээлийг илгээдэг. 1,3,5 өдөр 07 цаг 30 минутанд цахим хичээлийн тайлбарыг хийдэг.
- I, II улирлын хичээлийн жилийн эхний 15 хоногт бүх хичээлийн суурь болгон Профессор С.Амбагын “Хүн амьтны биеийн протон хамааралт бүхэллэг тогтолцооны систем загварт”-т цуврал хичээлийг Ректор ордог.

Анхаарах асуудал:

- Сувилахуйн багш нарын зохион байгуулдаг аян, хөтөлбөр, оролцоог сайжруулах.

Зөвлөмж:

- Сувилахуйн оюутны зөөлөн ур чадварыг хөгжүүлэх, тогтвортой хөгжлийн зорилтын хүрээн дэхь хүний эрх тэгш байдал, хууль эрх зүйн сургалтыг зохион байгуулах.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Шинэ АУИС нь сургуулийн оюутны зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 2020 оны хичээлийн жилээс эхлэн МОХ-оор батлуулан ажилладаг.
- Улаан загалмайн клубын оюутнуудын санаачилгаар “Энэрэл” эмнэлгээр үйлчлүүлдэг эмзэг бүлгийн хүмүүст зориулан “Сайн санааны аян”-ыг жил бүрийн 11 сард зохион байгуулж сургуулийн багш, оюутан, ажилтныг хамруулан сайн дурын хандивын аяныг өрнүүлэн хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгсэл, дархлаа дэмжих бүтээгдэхүүн өгч дэмжлэг үзүүлдэг.
- Засгийн газрын 2016 оны 178 дугаар тогтоолын хүрээнд оюутнуудыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, ажлын дадлага олгох, орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зөвлөх үйлчилгээ явуулдаг.
- Суралцагчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор сургуулийн харъяа байгууллага Хэнтий аймгийн Цэнхэрмандал суман дахь ургамал тарималжуулах биостанци, Хэрлэнбаян-Улаан дахь биохүрээлэнд хичээлийн бус цагаар ургамал тарих, суулгах, арчлах, ургамлын мөчлөгт судалгаа хийх, эмнэлзүйн бааз “Хулж Боржигон” эмнэлэгт ажиллах боломжоор хангаж, сувилахуйн бакалаврын хөтөлбөрийн суралцагч Б.Санжжав 2022 оны 09 сарын 01 өдрөөс одоог хүртэл туслах сувилагчийн орон тоонд 1.2 сая төгрөгний цалинтай ажилладаг.
- Шинэ АУИС-ийн төгсөгчдийн ажил эрхлэлт 90% дээш хувьтай байдаг. Сүүлийн 3 жилд нийт 33 оюутан төгссөн бөгөөд үүнээс лавлагаа шатлалын эмнэлэгт 5, дүргийн нэгдсэн эмнэлэгт 9, орон нутгийн ЭМБ 19 ажиллаж байна.
- Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг дээр оюутнууд 14 хоногийн сувилахуйн 2 кр дадлагыг хийж ажил олгогч хамтран ажилладаг.
- Сургуулийн ректор өөрийн биеэр 2022-2023 онд 6 сарын турш 21 аймгаар явж байгууллагуудад сургуулиа сурталчилж төгсөгчдийн ажил олголтыг сайжруулах чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулсан.
- 2022-2023 оны хичээлийн жилд 2 оюутан СХД-ийн сагсан бөмбөгийн тэмцээнд тэргүүн байранд шалгарсан.
- 2023-2024 онд сувилахуйн 1 дамжааны оюутан Д.Цэнгэл Шинэ АУИС-ийн ерөнхий эрдмийн тэнхимээс зохион байгуулсан хими, биологийн олимпиадад 2 дугаар байранд шалгарсан.
- Сургуулийн зүгээс амжилттай суралцаж байгаа, олон нийтийн ажилд идэвхтэй оролцдог оюутныг урамшуулан дэмжих зорилгоор төрөл бүрийн тэтгэлэгт хамрагдах, хөнгөлөлт эдлэх, нэрэмжит стипенди, ангийн дарга нарын сургалтын төлбөрийн 10% хөнгөлөх, гадаадад дадлага хийх зэрэг урамшуулалыг үзүүлдэг.
- Ректорын нэрэмжит тэтгэлэгт 2020-2021 оны хичээлийн жилд сувилахуйн бакалаврын хөтөлбөрийн 4 дамжааны оюутан Д.Уланбаяр 2 улирал дарааллан 4 голчтой суралцаж, 100000 төгрөгний стипенди авсан.
- 2020-2023 оны хичээлийн жилд цар тахалтай холбоотойгоор 1 дамжаанд элсэн суралцсан 87 оюутны төлбөрөөс 20 хувь хөнгөлсөн.

- NCM Анагаах ухааныг хэн сайн мэдэх вэ? Тэмцээнд түрүүлсэн суралцагчид Монгол Улсын төрийн шагналт, АШУ-ны доктор, профессор М.Амбагын нэрэмжит 3 сая төгрөгний шагналыг олгодог. Сувилахуйн бакалаврын хөтөлбөрийн суралцагчаас одоохондоо шалгараагүй байна.
- Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумаас сувилахуйн мэргэжлээр элсэн суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг 25% хөнгөлж байна. 2023 оны хичээлийн жилд оюутан Н.Амин-эрдэнийн сургалтын төлбөрийн 25%-ийг хөнгөлөлтөнд хамруулсан.
- 2020-2023 оны хичээлийн жилүүдэд 164 оюутан боловсролын зээлийн сангийн тэтгэлэгт хамрагдсан. 2021-2022 онд тэтгэлэгт-43, 2022-2023 онд тэтгэлэгт-45, 2023-2024 онд тэтгэлэгт-76 тус тус тэтгэлэгт хамрагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн ректорын шийдвэрээр Шинэ АУИС-ийн оюутны зөвлөл “Монголын оюутны холбооны” дэргэдэх сайн дурын байгууллага болон шинэчлэгдсэн. 2022-2023 оны хичээлийн жилд 3.2 сая төгрөгийн төсвийг батлуулан үйл ажиллагаандаа зарцуулсан. 2023-2024 оны хичээлийн жилд 2.650.000 төгрөгийг батлуулсан.
- Сувилахуйн сургуулийн оюутнууд Япон улсын Рейги Сөхоү соёлын нийгэмлэгтэй хамтран 2022 оны 11 сарын 10-аас хамтын ажиллагааны хүрээнд туслах сувилагчийн цалинтай дадлагыг 11 оюутан хийсэн.
- Ректорын 2021.10.14 өдрийн Б/78 тоот “ Оюутны зөвлөлийн тэргүүн болон дэд тэргүүнд урамшуулал цалин олгох” тушаалын дагуу ОЗТ Г.Цэвээнсүрэн сард 80.000, ОЗДТ Б.Тэнгис сард 30.000 төгрөгний урамшуулал олгодог.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Шинэ АУИС-ын захирлын 2017 оны 10 сарын 15-ны өдрийн А/13 тоот тушаалын 5.1-5.5 заалтын дагуу оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулдаг.
- Сургууль нь БШУС-ын 2021 оны А/348 тушаалын 1-р хавсралт болох “Дээд боловсролын зэрэг олгох сургалтанд багц цагийг дүйцүүлэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд баримтлах үлгэрчилсэн журам”-ын дагуу Шинэ АУИС-ын захирлын 2022.10.31 өдрийн А/70-01 тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Сургалтын үйл ажиллагааны кредит дүйцүүлэх журам”-ын заалтын дагуу шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэдэг.
- 2018-2023 оны хичээлийн жилд сувилахуйн бакалаврын хөтөлбөрт Анагаахын чиглэлийн бусад сургуулиас 9 оюутан шилжин ирж суралцсан. Харин тус сургуулиас 1 оюутан өөр мэргэжлийн сургууль руу шилжин явсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- “Дээд боловсролын диплом олгох журам” 2006 оны 12 сарын 29-ний өдрийн 480 тоот тушаал, Шинэ АУИС-ийн дүрмийн 5.10 заалтын дагуу төгсөлтийн баримт бичгийг олгодог. Шинэ АУИС-ын удирдах зөвлөлийн дарга, Ректор, төгсөлтийн шалгалтын комиссын дарга, Сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулан дипломын хавсралтыг Монгол, Англи, Уйгаржин хэлбэрээр Adobe indisein программаас шууд хэвлэдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Төгсөгчдийн дипломын дүнгийн хавсралт дахь хичээл, агуулгын багтаамж нь сургалтын төлөвлөгөөнөөс зөрж байгааг анхаарах.

5-р шалгуурын шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын Бодлого Зохицуулалтын Алба (даргын) ажил, үүргийн үндсэн чиглэл (Удирдлагын багийн хамт олон боловсруулсан)
- Шинэ АУИС-ийн багшийн хүрэх түвшин
- Шинэ АУИС-ийн багшийн 9 шинж
- Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, зэрэглэл, урамшууллын бодлого
- Багш суралцагчдын тооны харьцаа зохистой хэмжээ
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг тусгасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн сонгон шалгаруулалтын журамтай, түүн дээрээ нээлттэй байршуулж, багшаа сонгоно.
- Багшийн ур чадварыг сар бүр тогтмол тайланг үндэслэн урамшуулдаг
- Хувь хүний хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлдэг, жил бүр тооцож, өөрийгөө үнэлэх, удирдлага нь үнэлэх, хөндлөнгийн үнэлгээг тус тус хийж, нэгдсэн тайлангаар баталгаажуулдаг. Хамгийн үр дүнтэй багшид цалингийн урамшуулал олгодог,

- Ном сурах бичиг гаргасан багшид үнэгүй хэвлэж өгөхөөс гадна нэг удаагийн 3-5 сая төгрөгний урамшуулал олгодог
- Докторын зэрэг хамгаалсан багшид 300-500 мянган төгрөгний урамшуулал
- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын зардлыг үндсэн багшийн хувьд бүрэн даадаг
- Хөдөө орон нутаг, гадаад улсад дадлага болон судалгааны ажлаар явж байгаа тохиолдолд зардлыг бүрэн даана
- Урт богино хугацааны багшийн хөгжлийн сургалтын зардлын тодорхой хувийг байгууллагаас гаргадаг
- Төгсөлтийн дараах нарийн мэргэшил эзэмшиж байгаа тохиолдолд сургуулиас цалинг бүрэн олгодог.
- Хөгжлийн бэрхшээлтэй багш ажилтанд унааны зардлын нэмэгдэл олгодог

Анхаарах асуудал:

- Багшийн нөөцийн бүрдэл, ялангуяа сувилахуйн мэргэшсэн хүмүүсийн тоо цөөн
- Зэрэглэл ахих нь тушаалаар заагдсан, нарийн тодорхойгүй

Зөвлөмж:

- Их сургуулийн багшид тавигдах шаардлагын хүрээнд эрдэм шинжилгээний үйл ажиллагааг үндсэн ачаалалд тооцдоггүй, ачааллыг зөвхөн сургалтаар гүйцэтгэж байгаа тогтолцоогоо өөрчлөх

Шаардлага:

- Магистрын зэрэг хамгаалаагүй багш байгааг анхаарч шийдэх

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийг үе шаттай хөгжүүлж, урт, богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал 2023-2024 оны хичээлийн жилд ажиллаж байгаа багш нарын тушаал
- Шинэ АУИС-ийн хөдөлмөрийн дотоод журмын Багш, ажилтан, ажилчныг ажилд авах ба гэрээг дуусгавар болгох
- Хөтөлбөрийн багш нарын цагийн ачааллын судалгаа
- Багшийн хөгжлийн төв байгуулсан тушаал
- Багшийн хөгжлийн хөтөлбөр
- Багшийг хөгжүүлэх албаны төлөвлөгөө, тайлан
- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал
- Багш бүр өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө, Багшийн хөгжлийн төлөвлөгөө, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт, тайлан
- Багшийн мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлэх чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс дэмжлэг үзүүлдэг байдал (Ректорын их семинар, кредит сургалт, Ур чадварын тайлангууд)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжлийн батлагдсан хөтөлбөртэй, үүнийг хрээгжүүлж, хянадаг багшийн хөгжлийн төвтэй

- Гадаад дотоодын сургалтад багш нараа хамруулдаг, 7 хоногт 3 удаа ректорын их семинарыг танхим болон онлайнаар тогтмол зохион байгуулдаг
- Багш бүр хичээлийн жилд хувь хүний хөгжлийн хөтөлбөр боловсруулан ажилладаг

Зөвлөмж:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд жил бүр хийх ажлын төлөвлөгөөг гаргаад үр дүнг тооцож ажиллах, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх
- Анагаах ухааны боловсрол судлалын чиглэлээр мэргэшсэн багш нарын сургалтыг зохион байгуулах

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багш нарыг гадаад, дотоодод туршлага судлуулсан эрдэм шинжилгээний удирдамжийн байдал
- Шинэ АУИС-ийн залуу багш нарыг судалгааны ажилд гаршуулан, чадваржуулах, шинэ аргазүйг нэвтрүүлсэн байдал
- Долоо хоног бүрийн 5 дахь өдөр зохион байгуулагддаг Ректорын их семинар /Лекц №1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9/
- Долоо хоног бүрийн 2, 4 дэх өдөр зохион байгуулагддаг NCM-Систем загварын тэнхимтэй хамтран нийт багш нарын туршлага солилцох семинар, лекц
- Багш нарын хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулдаг байдал
- Эрдэм шинжилгээ, судалгаа: Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентын тоо
- Залуу судлаачдыг дэмжих, судалгааны аргазүйд суралцуулах чиглэл
- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд багш судлаачдын бүтээлийг хэвлүүлэх чиглэлээр баримталж байгаа бодлого, дэмжлэг үзүүлсэн байдал (Багш нарын Бүтээлийн жагсаалт)
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулж байгаа төсөвийн бүрдүүлэлт ба зарцуулалт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Эрдэм судалгааны ажлынхаа үр дүнг практикт шууд нэвтрүүлдэг
- Сургуулийн алсын хараа эрхэм зорилго болон байгууллагын соёл хичээлийн агуулгад хүртэл судалгааны үр дүнгээ шингээж ажилладаг
- Судалгаа хийх лаборатори хангалттай, хийх боломж нь нээлттэй, нийт 21 чиглэлийн лабораторийн нөхцлийг бүрдүүлж чадсан
- Эрдэм судалгааны бүтээл олонтой жишээ нь Амбага докторын 262 боть цахим, 100 гаруй нь хэвлэмэл хэлбэрээр байна
- Эрдэм шинжилгээ инновацын төвийг байгуулж, эмийн ургамлын тусламжтайгаар шинэ бүтээгдэхүүнийг бүтээх ажлыг тогтвортой хийдэг

- Судалгааны арга зүйн чиглэлээр сургалт зохион байгуулж, шинэ аргачлалыг нэвтрүүлдэг
- Гадаад өгүүллийн тоо сүүлийн 10 жилд гэхэд 140, гадаад илтгэл 99, дотоодод 210 илтгэл, дотоод өгүүлэл 239 байна

Анхаарах асуудал:

- Эрдэм судалгааны ачааллыг үндсэн ачаалалд оруулж, тогтмол судалгаа хийх нөхцлийг шаардах
- Сувилахуйн хөтөлбөр хэрэгжүүлэгч Сувилагч мэргэжлийн багш нарын эрдэм шинжилгээ, өгүүлэл, бүтээлийн тоо бага байгааг анхаарах

Зөвлөмж:

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн үнэлгээ: Багшийн өөрийн үнэлгээний тайланд дүн шинжилгээ хийсэн байдал
- Сар бүрийн ур чадварын урамшуулалт цалин (Сар бүрийн ур чадварын тайлан)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ур чадварын үнэлгээг сар бүр хийдэг ба энэ нь бүгдэд нээлттэй байдаг
- Мэргэжлийн ажлын үнэлгээг хүн тус бүрээр хийж, урамшуулдаг
- Багшийн ачааллын тооцоог хичээлийн жилийн төгсгөлд 6 сард хийх ба илүү цагийн үнэлгээ сайтай
- Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээ тогтмол хийгддэг
- Гэрээт багш нартай гэрээг албан ёсоор хийдэг ба цагийн үнэлгээг улирлын төгсгөлд тооцож олгодог

Анхаарах асуудал:

- Багшийн ачааллыг зөвхөн сургалтаарх ачааллаар үнэлдэг
- Багшийн заах арга зүйн чиглэлээр үнэлгээ хийгдэггүй

Зөвлөмж:

- Багшийн заах арга зүйн чиглэлээр үнэлгээ хийж хэвших

6-р шалгуурын шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- БСШУЯСайдын 2014 оны А/174 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-аар хөтөлбөр шинэчилсэн байна. Хяналт үнэлгээний баг нь захирлын баталсан тушаалын дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээний албаны ажлын төлөвлөгөөтэй, үнэлгээний албаны ажлын гол чиглэл, ажиллах журам зэргийг батлуулан ажиллаж байна. (хавсралт) МУ-ын стандартчлалын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан MNS 5323/124, УАУ-ы/128, Эм зүйн/126, Сувилахуйн/129 стандартуудын хичээл нэг бүр дээрх хэрэгжилтийг “Соёмбо мэдлэг–NCM мэдлэгт суурилсан гуравласан хөтөлбөрөөр” явуулж буй байдал болон байгууллагын бусад нэгжийн үйл ажиллагаанд чанарын дотоод хяналтыг хийж байна.
- Хичээлийн үр дүнгийн (CLO) талаар асуулгаар 2022-2023 оны хичээлийн жилийн 1-р семестрт орсон зарим хичээлийн явцыг үнэлж хөтөлбөрийн дагуу орж буй хичээлийн үр дүн, үйл ажиллагааг оюутнууд хэрхэн дүгнэж байгааг тодорхойлох зорилгоор уг судалгаа хийсэн байна. NCM-сувилахуйн сургуулийн СС06, NCM эрдмийн сургуулийн ЭС22, ЭС17, ЭС12 гэсэн багшийн кодтой багш нарын дадлагын хичээлд сууж хичээлийн үр дүнг суралцагч оюутнуудаас (АУ-103, АУ-302, АУ-205, АУ-202 хэсгийн оюутнууд) дараах асуумжуудын дагуу авч дүнг гаргасан. Үүнд: Сургалтын орчинг оюутанд ээлтэй, тухтай байлгах, эмнэлзүйн сургалтын орчинг сайжруулах, сургуулийн цэвэрлэгээг сайжруулах–44,4%, Гардан үйлдэл, дадлагыг бодит үзлэгтэй хослуулж хичээлээ орох–44,4%, Анги танхимын хүрэлцээг сайжруулах–55,6%, Ном, сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх–11,1%, Оюутны зоогийн газрын үйл ажиллагааг сайжруулах–11,1% гэж гарсан байна. Сэтгэл ханамжийн судалгаанд дүгнэлт хийж зохих ажилуудыг зохион явуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

- Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал 95% байна, одоо ажиллаж байгаа төгсөгчдийн сэтгэл ханамж өндөр ажлын байранд, магистрын ажил зэрэгт NCM онолыг хэрэгжүүлэгч байна. Ажил олгогч нарын хэрэгцээ шаардлага хангасан сувилагч нарыг бэлтгэн гаргаж байгаа нь ярилцлагаас харагдлаа. Мөн төгсөн гарч буй сувилагчийн онцлогоос шалтгаалж хүн бүр харилцан адилгүй чанартай байдаг байна. Харин ажил олгогч нараас сэтгэл ханамжийн судалгаа, хөтөлбөрийн агуулгын судалгаа зэргийг тогтмол аваагүй байна. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа 95% байгаа хэдий ч төгсөгчдийн сургалтын чанар, гардан ур чадварыг сайжруулах, харилцаа хандлагыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага ярилцлагаас харагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Ажил олгогч нараас цахим судалгааг жил бүр тогтмол жигд авч байх

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

- Гадаад хамтын ажиллагаа болон бусад холбоо нийгэмлэгтэй хамтран ажилладаг байна. Үүнд: Шинэ анагаах ухаан их сургууль болон Реги Саху соёлын нийгэмлэгийн хамтын ажиллагааны хүрээнд Япон улсад 10 сарын хугацаатай цалинтай дадлагад 2023 оны 10 сараас нийт 11 оюутан хамрагдаж байна. Дараагийн ээлжинд явахаар 15 оюутан Япон хэлний сургалтанд хамрагдаж байна.
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилладаг талаар: Монголын сувилагчдын нийгэмлэг, Мэс засалчдын мэргэшсэн сувилахуйн нийгэмлэг, Монголын сувилахуйн шинжлэх ухааны академи, ЭМХТ-тэй хамтран төгсөлтийн дараах багц цагийн сургалт, эрдэм шинжилгээний хурал, хөтөлбөр боловсруулах зэрэг ажлуудыг хамтран зохион байгуулдаг. Мөн СХД-ийн хүүхэд залуучуудын төвтэй хамтран зөв боловсон хүн болж төлөвшүүлэх сургалтуудыг оюутнуудынхаа дунд явуулдаг. СХД-ийн цагдаагийн хэлтэстэй хамтран оюутнуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Дотоод аудит бэлтгэх, баг ажиллуулах
- Сувилахуйн сургууль болон бусад сувилахуйн сургуулийн багш нараас мэргэжлийн зөвлөгөө авах туршлага судлах, гардан үйлдэлд багш нар гар нийлэх зэрэг ажлыг зохион байгуулах

Зөвлөмж:

7-р шалгуурын шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	2	1		Сургалтын хөтөлбөрийн агуулгын хэмжээ их, хичээлийн хөтөлбөрийн агуулга, төлөвлөгөөн дэх агуулгын хэмжээнээс зөрүүтэй байна
2	Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	3			
3	Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2	1		Сувилахуйн гардан ажилбарын сургалтын өрөөг эмнэлгийн орчинд дүйцүүлэх, багаж хэрэгслэл, аппарат тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна
4	Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			
5	Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			
6	Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	3	1		Үндсэн багш магистрант байна
7	Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	3			
		23	3		
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Шинэ Анагаах Ухаан их сургуулийн “Сувилахуй” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл Мэндийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг /Б.Оюунгоо/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Н.Мөнгөнсор/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Ю.Оюунзул/

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийн багтаамж хэт их 188 кр байгааг журамд нийцүүлэн бууруулах Хичээлийн хөтөлбөрүүдийг (анхаарах асуудалд дурьдсны дагуу) шинэчлэн боловсруулах, хөтөлбөр дэх агуулга төлөвлөгөөн дэх агуулгын хэмжээ зөрүүтэй байгааг засах
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Сургалтын үйл ажиллагаанд сургалтын дэвшилтэд технологи ашиглах, сувилахуйн түгээмэл үйлдлийг стандартын дагуу E контент боловсруулах Сувилахуйн багш нар сувилахуйн төгсөлтийн шалгалтын өртөө тус бүрийн тохиолдол, үнэлгээний хуудас бүхий оюутны гарын авлагыг боловсруулах
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none">
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнд багш, оюутан, ажил олгогчийн төлөөллийг оруулах
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Сувилахуйн оюутны зөөлөн ур чадварыг хөгжүүлэх, тогтвортой хөгжлийн зорилтын хүрээн дэхь хүний эрх тэгш байдал, хууль эрх зүйн сургалтыг зохион байгуулах.
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Их сургуулийн багшид тавигдах шаардлагын хүрээнд эрдэм шинжилгээний үйл ажиллагааг үндсэн ачаалалд тооцдоггүй, ачаалыг зөвхөн сургалтаар гүйцэтгэж байгаа тогтолцоог өөрчлөх
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	
Шаардлага	
Шалгуур 1 Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> Сургалтын хөтөлбөрийн агуулгын хэмжээ их, хичээлийн хөтөлбөрийн агуулга, төлөвлөгөөн дэх агуулгын хэмжээнээс зөрүүтэй байгааг арилгах
Шалгуур 3 Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> Сувилахуйн гардан ажилбарын сургалтын өрөөг эмнэлгийн орчинд дүйцүүлэх, багаж хэрэгслэл, аппарат тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх
Шалгуур 6 Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Магистрын зэрэг хамгаалаагүй багш байгааг анхаарч шийдэх

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Овог нэрс	Албан тушаал	Заадаг хичээл	Утас
0	Б.Ачлалт	Англи хэлний багш	Англи хэл -1, 2	89990383
2	Б.Ганчимэг	Биологийн багш	Биологи	90909897
3	Б.Наранчимэг	Анагаахын химийн багш	Анагаахын хими	99771382
4	Б.Уртнасан	NCM-Систем загварын тэнхимийн эрхлэгч	Эмгэг физиологи NCM-Сувилахуй	99040266
5	Э.Донойдугар	Түүх хичээлийн багш	Монголын түүх	96090130
6	Ц.Жавзансүрэн	СБЗА-ны дэд дарга, Үндэсний (худам) монгол хэл, бичиг хичээлийн багш	Монгол хэлний найруулга зүй	94614292
7	Б.Сугармаа	NCM эм зүйн асуудал, NCM онолын асуудлууд, эрүүл физиологи 1 хичээлийн багш	Эрүүл физиологи-1, 2	89807068
8	Г.Орхонтуяа	АУ-ы удам зүйн хичээлийн багш	Анагаах ухааны удам зүй, Бичил амь судлал	88770508
9	Д.Батболд	NCM-Сувилахуйн сургуулийн дэд захирал, Насанд хүрэгчдийн сувилахуйн тэнхимийн эрхлэгч	Сувилахуйн үндэс, Нийгмийн эрүүл мэнд судлал Эпидемиологи, биостатистик, Эрүүл мэндийн үнэлгээ, Өвчтөний аюулгүй байдал	99732136
10	С.Чулуунцэцэг	СБЗА-ны Сувилахуй хариуцсан мэргэжилтэн, Сувилахуйн ур чадвар хичээлийн багш	Сувилахуйн ур чадвар	89096266
11	Г.Амаржаргал	Сувилгааны үйл ажиллагаа, Настны сувилахуй хичээлийн багш	Нүүр амны сувилахуй, Сувилахуйн яаралтай тусламж, Сувилгааны үйл ажиллагаа, Настны сувилахуй	89018105
12	С.Цэцэгээ	Хүүхдийн сувилахуй-1, 2, хичээлийн багш	Хүүхдийн сувилахуй-1, 2,3	99902509
13	М.Жигжидноров	Эм судлал хичээлийн багш	Эм судлал	98868623
14	Б.Оюунжаргал	Нүдний өвчний сувилахуй хичээлийн багш	Нүдний өвчний сувилахуй, Чих, хамар, хоолойн сувилахуй, Сэргээн	99067443

			засах үеийн сувилахуй	
15	Н.Хулан	Мэдрэлийн өвчний сувилахуй, Сэтгэн бодох, шийдвэр гаргах арга зүй хичээлийн багш	Мэдрэлийн өвчний сувилахуй Сэтгэцийн эрүүл мэнд ба сувилахуй Сэтгэн бодох, шийдвэр гаргах арга зүй	89091244
16	У.Цэрэндолгор	НСМ-Сувилахуйн сургуулийн захирал	Хоолоор сувилахуй Эпидемиологи, биостатистик	99265974
17	С.Ундармаа	Багш	ДОХ, Бэлгийн замаар дамжих халдвар , Арьсны өвчний сувилахуй Сүрьеэ	99177154
18	Б.Ганзориг	СБЗА-ны дэд дарга	Дотрын сувилахуй	99682001
19	Б.Цэгмид	Арьсны өвчин- Халдварт өвчин судлалын тэнхимийн эрхлэгч	Халдварт өвчний сувилахуй	99569352
20	Б.Эрдэнэнамжилмаа	Багш	Өргөжүүлсэн сувилахуйн дадлага	98018801

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	Нэргүй Мичидмаа	СУВ-101		99856983
2	Шаарав Отгонжаргал	СУВ-101		88319328
3	Дэлгэрмаа Цэнгэл	СУВ-101		88879701
4	Чинбат Энхжин	СУВ-202	Дотуур байранд амьдардаг	85323209
5	Батхишиг Амгалантуул	СУВ-202		88947937
6	Намжилдавга Намжилмаа	СУВ-202	Орон нутгийн	89122172
7	Цэвэлмаа Янжиндулам	СУВ-302		86610215
8	Цэнд-Аюуш Бадамханд	СУВ-301	Дотуур байранд амьдардаг	95529887
9	Жаргалсайхан Юмжирлхам	СУВ-301		80168627
10	Баярхүү Наранзул	СУВ-301		99518809
11	Ганболд Сумъяажаргал	СУВ-402	Орон нутгийн	85149412
12	Сарантуяа Хулан	СУВ-402		99258430
13	Нэргүй Амин-Эрдэнэ	СУВ-401	Орон нутгийн	99579827
14	Ганбаатар Арвинхишиг	СУВ-401	Орон нутгийн	80889854
15	Төмөрхуяг Отгонцэцэг	СУВ-401	Орон нутгийн	88471869

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал	Утас
1	К.Мөнхзул	Юнимед эмнэлэг, Хүний нөөц	99019495
2	Г.Алтанцэцэг	Сонгино хайрхан нэгдсэн эмнэлгийн Амбулаторийн тасгийн эрхлэгч	88014029
3	М.Зоригт	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв-ийн Мэргэжлийн өвчин судлалын газрын дарга	99042627
4	Самбуу Энхтуяа	Увс аймгийн 0245 дугаар отрядын их эмч	88049484
5	Тогтох Саранчимэг	Дорнод аймгийн нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасгийн ахлах сувилагч	80489000
6	Ц.Хишигбадам	ХУДНЭ-ийн хүүхдийн тасгийн ахлах сувилагч	99290107
7	М.Энхтуяа	УХТЭ-ийн Мэдрэл судлалын тасгийн ахлах сувилагч	99837870
8	Б.Тэмүүжин	Говьсүмбэр аймгийн ШШГГ-ын дэд дарга	88053266
9	Д.Оюунчимэг	СХНЭ-ийн Сувилахуйн албаны дарга	89123243

IV. Төгсөгчдийн нэрс

№	Төгссөн он	Төгсөгчдийн нэр	Ажлын газрын нэр, утасны дугаар	Ажил олгогчийг төлөөлж оролцож буй хүний нэр, утасны дугаар	Ажил олгогчийн албан тушаал
1	2023 он	Г.Түмэнжаргал	Төв аймгийн Алтанбулаг сум, зэвсэгт хүчний 311-р ангид сувилагч, 88042741		
2		М.Шинэсаран	Мэргэжлийн өвчин судлалын төвд сувилагч, 88589479	М.Зоригт, 99042627	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв-ийн Мэргэжлийн өвчин судлалын газрын дарга
3		А.Солонго	Дорнод аймгийн нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасагт сувилагч, 94836131	Тогтох Саранчимэг, 80489000	Дорнод аймгийн нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасгийн ахлах сувилагч
4		Д.Уранбайгаль	Төв аймгийн нэгдсэн эмнэлэгт сувилагч, 89290949		

5	П.Отгонханд	Гэмтэл согог судлалын үндэсний төвд сувилагч, 94385622		
6	П.Анхтуяа	Хүүхэд харах чөлөөтэй байгаа, 86834429	К.Мөнхзул, 99019495	Юнимед эмнэлэг, Хүний нөөц
7	А.Ангараг	БЗД-ийн 19-р хорооны ӨЭМТ-д сувилагч, 88632057		
8	Б.Хандсүрэн	Говьсүмбэр аймгийн ШШГГ-т сувилагч, 88776477	Б.Тэмүүжин, 88053266	Говьсүмбэр аймгийн ШШГГ-ын дэд дарга
9	А.Норов	ХУД-ийн эмнэлгийн тасагт сувилагч, 86990133	Ц.Хишигбадам, 99290107	ХУД-ийн нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн тасгийн ахлах сувилагч
10	Ж.Нандинзул	Улсын хоёрдугаар төв эмнэлэгт сувилагч, 99873689	М.Энхтуяа, 99837870	УХТЭ-ийн Мэдрэл судлалын тасгийн ахлах сувилагч
11	Д.Цэрэннадмид	Завхан аймгийн нэгдсэн эмнэлэгт сувилагч, 89466550		
12	Ц.Эвзаяа	Увс аймгийн дугаар ангид сувилагч, 99455006	Самбуу Энхтуяа, 88049484	Увс аймгийн 0245 дугаар отрядын их эмч
13	Д.Уламбаяр	СХД-ийн нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасгийн тарианы сувилагч, 94432393	Г.Алтанцэцэг, 88014029	Сонгино хайрхан нэгдсэн эмнэлгийн Амбулаторийн тасгийн эрхлэгч
14	Ц.Номин-Эрдэнэ	Төв аймгийн Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвд сувилагч, 95195796		
15	Б.Санжжав	Хулж боржигон эмнэлгийн сувилагч, 86158424	Б.Наранцэцэг, 99047151	Хулж боржигон эмнэлгийн ерөнхий эмч

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



**“ШИНЭ АНАГААХ УХААН”
ИХ СУРГУУЛЬ**

**ШИНЖЛЭХ УХААН - СУРГАЛТ - ЭМЧИЛГЭЭ
- ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОР**

Улаанбаатар хот, Zip code-18130
Сонгинохайрхан дүүрэг-20
Сонсголон /18130/Товчооны зам 5/2
Утас: 70183235 Факс: 976-70183235
E-mail: info@ncm.edu.mn
Website: www.ncm.edu.mn

2023.12.22 № 298
танай _____ № _____ -Т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛД**

Санал хүргүүлэх тухай

Шинэ Анагаах Ухаан Их Сургуулийн D091301 NCM-Сувилахуйн хөтөлбөрт ажилласан шинжээчийн багаас ирүүлсэн тайлантай танилцаад шинжээчийн тайланг хүлээн зөвшөөрч байгааг уламжилж байна.

РЕКТОР, ПРОФЕССОР



М.АМБАГА

